



МОНГОЛ УЛСЫН СОЁЛ, СПОРТ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН
САЙДЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/131

Улаанбаатар хот

Жендерийн салбар зөвлөлийн
бүрэлдэхүүнийг томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дэх хэсэг, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 227 дугаар тогтоолоор баталсан Жендерийн үндэсний хорооны дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жендерийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр тухайн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг жил бүрийн яамны үйл ажиллагааны төлөвлөгөөнд төсвийн хамт тусган батлуулж, хэрэгжилтэд хяналт тавих, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Жендерийн салбар зөвлөлийн дарга (Б.Бат-Эрдэнэ)-д даалгасугай

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Жендерийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай” Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/13 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ч.УНДРАМ

14190010318

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын
сайдын 2026 оны 09 дугаар сарын 27-ны
өдрийн 4/ дугаар тушаалын нэгдүгээр
13/ хавсралт

ЖЕНДЕРИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ATA12931 6594204 9024070548

Салбар зөвлөлийн
дарга:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн
нарийн бичгийн дарга

Гишүүд:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн
газрын дарга

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир,
спортын улсын хорооны дарга

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны
Бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны
Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Соёл,
урлагийн бодлого, зохицуулалтын газрын дарга

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал
жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны
Биеийн тамир, спорт, залуучуудын бодлого
зохицуулалтын газрын дарга

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны
Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын
газрын дарга

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны
Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны
Статистикийн дүн шинжилгээ, мэдээллийн нэгтгэл
хариуцсан ахлах мэргэжилтэн

Монгол Улсын Үндэсний номын сангийн захирал

Монгол Улсын Үндэсний музейн захирал

Улсын Драммын Эрдмийн Театрын захирал

Монгол Улсын Филармонийн захирал

“МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээ” ТББ-ын захирал /ЖҮХ-оос санал авч, зөвшилцсөнөөр/

“Аялгуут тэнгэр сан” ТББ-ын тэргүүн /зөвшилцсөнөөр/

Монголын Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны гүйцэтгэх захирал /зөвшилцсөнөөр/

Монголын Үндэсний Олимпын Хорооны Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн /МҮОХ-оос санал авч, зөвшилцсөнөөр/

Монголын залуучуудын эвсэл ТББ-ын захирал /зөвшилцсөнөөр/

Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Жендер, хүний эрх, хөдөлмөрийн аюулгүй байдал, гамшгийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн